



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН НЭР: ШУТИС, МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ

ХӨТӨЛБӨРИЙН НЭР: ЛОГИСТИК МЕНЕЖМЕНТ

ИНДЕКС: D041305

ШИНЖЭЭЧИЙН БАГ:

АХЛАГЧ: Д.АНХТУЯА Санхүү эдийн засгийн их сургуулийн платформ
түншлэл хариуцсан проректор

ГИШҮҮД: Н.ОТГОНСАЙХАН Худалдаа, үйлдвэрлэлийн Их сургуулийн худалдаа,
маркетингийн тэнхмийн эрхлэгч доктор, профессор

Д.БАТ-ОРГИЛ Зам, тээврийн хөгжлийн яамны Хөдөлгөөн зохицуулалтын
нэгдсэн төвийн ахлах мэргэжилтэн

Он сар өдөр: 2021-12-20

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- ГТХЗНТ УТҮГ (Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв Улсын төсөвт үйлдвэрийн газар)
- ТЗДС (Төмөр замын дээд сургууль)
- ЗТХЯ (Зам, тээврийн хөгжлийн яам)
- БМИҮЗ (Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл)
- UNIMIS (University's management information system)
- EASTS (Eastern Asia Society for transportation studies)
- ЧМТ (Чанарын менежментийн тогтолцоо)
- СХБА (Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба)
- ЧДБ (Чанарын дотоод баталгаажуулалт)
- ЭШИГ (Эрдэм шинжилгээ инновацийн газар)
- СБЗГ (Сургалтын бодлого зохицуулалтын газар)
- МехТС (Механик, тээврийн сургууль)
- ХЕХ (Хөтөлбөрийн ерөнхий хороо)
- ШУТИС (Шинжлэх ухаан технологийн их сургууль)
- ИДС (Их дээд сургууль)
- ХШҮГ (Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар)
- ЗӨАТСН (Зүүн өмнөд Азийн тээвэр судлалын нийгэмлэг)

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	ШУТИС, Механик Тээврийн сургууль	
Хөтөлбөрийн нэр, индекс	Логистик Менежмент, D041305	
Шинжээчид	<p>Д.Анхтуяа Санхүү эдийн засгийн их сургуулийн платформ түншлэл хариуцсан проректор</p> <p>Д.Бат-Оргил Зам, тээврийн хөгжлийн яамны Хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ахлах мэргэжилтэн</p> <p>Н.Отгонсайхан Худалдаа, үйлдвэрлэлийн Их сургуулийн худалдаа, маркетингийн тэнхмийн эрхлэгч доктор, профессор</p>	
Зохицуулагч	Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	Өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021.11.18	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2021.12.03	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2021.12.05	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2021.12.09,10	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2022.01.20	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
	2022.01.21	Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ШУТИС-ийн Механик Тээврийн сургуулийн D041305 индекстэй, Логистик менежмент бакалаврын өдрийн хөтөлбөр нь шинжлэх ухааны цогц мэдлэгтэй, тээвэр логистикийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, оновчтой шийдвэр гаргах чадвартай, өөрчлөлтөд дасан зохицох, манлайлах, багаар ажиллах, мэдээллийн технологи ашиглах, өөрийгөө үнэлж, сайжруулах, судалгаа шинжилгээ хийх дадал хэвшилтэй, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц нийгмийн хариуцлагатай, гүйцэтгэх болох удирдах ажилтныг бэлтгэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Логистик, тээврийн менежментийн хөтөлбөрийн баг нь 2001 онд Механик Инженерийн Сургууль (МехТС)-ийн бүтцэд “Суурь боловсролын тэнхим” нэртэйгээр анх үүсгэн байгуулагдаж, “Тээврийн менежмент”, “Олон улсын тээврийн менежмент” мэргэжлүүдээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. 2004 онд Тээврийн логистик, менежментийн, 2010 оноос Логистик, тээврийн менежментийн профессорын баг нэртэйгээр ажиллаж байгаад 2014 оны ШУТИС-ийн бүтцийн өөрчлөлтөөр Тээврийн салбарт харьяалагдан ажиллах болсон. Тус багт өнөөдрийн байдлаар 6 үндсэн багш, 1 ахмад гэрээт багш ажиллаж байгаагаас 5 доктор (Ph.D) тогтвор суурьшилтай ажиллаж байна. 2001 оноос Тээврийн менежмент, 2009 оноос Логистикийн менежмент, 2020 оноос Төмөр замын тээврийн менежмент мэргэжлээр элсэлт авч орчин үеийн тээвэр, логистикийн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэж ирсэн. Логистик менежментийн хөтөлбөрийг Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2014 оны 03 сарын 13-ны өдрийн №А/78 тоот тушаал, 2014 оны 04 сарын 28-ны өдрийн “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” №А/174 тоот тушаал, ШУТИС-ийн ректорын 2014 оны 05-р сарын 06-ны өдрийн “Журам батлах, хөтөлбөрийн хороо байгуулах тухай” А/76 тоот тушаалыг мөрдлөг болгон боловсруулсан байна. Хөтөлбөрийн баг нь Гонконгийн Техникийн Их Сургууль, Испани улсын Наваррагийн их сургууль, Орос улсын Иркутск хотын Эдийн засгийн академи, Япон улсын Цукубагийн их сургууль, Азийн тээвэр судлаачдын холбоо, Хятад улсын Тээвэр, барилгын үндэсний холбоо зэрэг гадаадын 10 гаруй байгууллагатай хамтын ажиллагаатай ажиллаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн
- Зах зээлийн хоосон орон зайг олж харсан /бенчмарк/
- 2 хөрштэй хамтарсан хөтөлбөр нээхээр ажиллаж байгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Гадаад орны их сургуультай хамтарч 2 дээр нэмэх 2 хөтөлбөр боловсруулж хөтөлбөрийн өөр хувилбар хэрэгжүүлэх боломжтой ба хэлэлцээрийн шатанд явж байна.
- БНХАУ, ОХУ-тай хамтарсан 3 улсын хамтарсан хөтөлбөр нээх ажлыг гэрээний эхлүүлсэн байна.
- Мэргэжлийн хэрэгцээ шаардлагын чухал болохыг эртнээс олж харсан ба Монгол улсын анхны хөтөлбөр

Анхаарах асуудал:

- ✓ Логистикийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгаа болон ажил олгогч, төгсөгчдийн саналыг тогтмол хугацаанд авч, хөтөлбөрийн шинэчлэлтэд тусгах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн хөгжүүлэлт хийхдээ Монгол улстай ижил далайд гарцгүй орны их сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулах, олон улсын ИДС-ийн сургалтын төлөвлөгөөнд заавал орохоор тусгасан хичээлийн жагсаалтыг гаргаж ажиллах
- ✓ Логистикийн салбарыг төрийн бодлогоор дэмжиж байгаа энэ үед элсэлтийн бодлого, дүрэм журмаа уян хатан болгох
- ✓ Мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчдийн уулзалтыг тогтмолжуулж, тэдний санал хүсэлтийг авч, сургалтын хөтөлбөртөө сайжруулалт хийж хэвших

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

- Сургуулийн эрхэм зорилго ба хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтууд хоорондын уялдаа, холбоог харьцуулалт хийгдсэн
- Дублины технологийн институт, Мариландын их сургууль, АНУ-ын Maritime Academy College, HAN хэрэглээний шинжлэх ухааны их сургууль, Бээжингийн Жаутонгийн их сургууль, Мандах их сургууль, ТЗДС-ийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа
- ISO:9001 хэрэгжүүлсэн байдлын тайлан
- CDIО стандарт хэрэгжүүлсэн тайлан
- STEEP шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Хөтөлбөрийн зорилгыг ШУТИС болон МехТС-ийн зорилготой уялдуулсан.
- Үндэсний болон олон улсын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулсан байна
- Гадаадын 10 гаруй байгууллагатай хамтын ажиллагаатай (Гонконгийн техникийн их сургууль, Испани улсын Наваррагийн их сургууль, Орос улсын Иркутск хотын Эдийн засгийн академи, Япон улсын Цукубагийн их сургууль, Азийн тээвэр судлаачдын холбоо, Хятад улсын Тээвэр, барилгын үндэсний холбоо г.м)

Анхаарах асуудал:

- ✓ Гадаад хэл, мэдээллийн технологийн хичээлээр мэдлэг, ур чадвар олгож байгаа хэдий ч оюутан, төгсөгчийн сэтгэл ханамж тааруу байгаа тул хичээлийн хөтөлбөр, агуулга, заах арга зүй зэрэгт гарц үр дүнгийн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- ✓ Мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчдийн уулзалтыг тогтмолжуулж, тэдний санал хүсэлтийг авч, сургалтын хөтөлбөртөө сайжруулалт хийж хэвших (Уулзалтын үр дүнгээс)

Шаардлага: /Бүрэн хангасан бол бичихгүй/

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Логистик менежментийг хөтөлбөрийг Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2014 оны 03 сарын 13-ны өдрийн №А/78 тоот тушаал, 2014 оны 04 сарын 28-ны өдрийн “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” №А/174 тоот тушаал, ШУТИС-ийн ректорын 2014 оны 05-р сарын 06-ны өдрийн “Журам батлах, хөтөлбөрийн хороо байгуулах тухай” А/76 тоот тушаалыг мөрдлөг болгон боловсруулж батлуулдаг.
- Логистикийн мэргэжлийн баг нь сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулж батлуулдаг ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг хичээл бүрээр харуулсан уялдаа холбооны матрицыг хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Хөтөлбөрийг боловсруулахдаа ШУТИС-ийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулдаг

- 2014, 2016 онд боловсруулагдсан хөтөлбөрт 2018 онд өөрийн үнэлгээ хийсэн, 2020 онд шинэчлэн сайжруулах саналаа ШУТИС хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн баримт бичгийн баталгаажуулалтын огнооны зөрүү хэт их байна. Иймд ШУТИС болон МехТС-ийн хоорондын уялдааг сайжруулж, баримт бичгийн бүрдүүлэлтийг нягт нямбай хийхэд анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн холбогдолтой баримт бичиг, нотолгоог хадгалах, архивжуулах ажил хариуцсан ажилтан, алба нэгжийг тодорхой болгож, ажил үүргийн хуваарийг ажлын байрны тодорхойлолтод тусган ажиллах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

- Сургалтын агуулгыг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцүүлсэн байдлыг харуулсан хүснэгт
- Удирдлагын мэдээллийн систем (UNIMIS)
- Хичээлийн залгамж холбоог харуулсан схем (flowchart)
- Оюутны цагийн ачааллын судалгаа
- Оюутан, төгсөгч, ажил олгогчдийн уулзалтын үр дүн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Оюутан хичээл, багшаа сонгох боломжийг UNIMIS ба цахим хичээлийн дэд системээр бүрдүүлсэн
- 3 дадлагатай

Анхаарах асуудал:

- Дадлагын баазуудтай албан ёсны гэрээ байгуулж хэвших

- Логистикийн мэргэжлийн хичээлд лицензтэй программ хангамж ашиглах боломжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Дадлагын удирдамжийг дадлага хийх байгууллагуудтай хамтран шинэчлэх замаар удирдагч багш, удирдагч ажилтан, оюутны үүрэг, хариуцлагыг тодорхой болгох

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

- Суралцахуйн үр дүнг тодорхойлох арга зүйн зөвлөмж <http://cdio.edu.mn>
- UNIMIS, MS teams болон бусад дэд цахим систем
- Light board студи, логистик нийлүүлэлтийн орчин үеийн схемчилсэн зураглал
- Бүтээлч сэтгэлгээний арга хэлбэр, сургалтын арга зүйг хичээлд ашиглах зөвлөмж

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- CDIO загварын дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын үйл ажиллагааг үнэлэхдээ 12 стандартыг мөрддөг.
- Хөтөлбөрийн хичээлүүдийн сургалтын арга зүйг тодорхойлохдоо Блумын мэдлэг, сэтгэлгээний таксономыг Андерсоны шинэчилсэн загварыг ашигладаг.
- Хичээлийн суралцахуйн үр дүн /CLO/-г тодорхойлж, идэвхтэй сургалтын аргуудыг багш бүр өөрийн арга зүйтэй уялдуулдаг.

Зөвлөмж:

- Сургалтын орчин үеийн арга зүйг эзэмшсэн багшийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх (бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд)

.....

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Оюутны мэдлэгийг үнэлэх журам
- Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам

- Оюутны дүнгийн шинжилгээ (ГД-ийн өсөлт, бууралт, 70/30 онооны шинжилгээ) хийгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Оюутны дүнгийн шинжилгээг хичээл бүрээр, улирал тутам хийж хэвшсэн
- Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх системтэй

Анхаарах асуудал:

- Танхим ба цахим сургалтын үед оюутны үнэлгээнд гарч буй өөрчлөлтийг харьцуулсан шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Оюутны дүнгийн шинжилгээнд үндэслэн суралцагчийн үнэлгээг тасралтгүй сайжруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

- Анги, танхим, лаборатори, номын сангийн хүрэлцээ хангамж, ашиглалтын талаарх сэтгэл ханамжийн судалгаа, тайлан
- Багш, суралцагчдын өрөөний талбай стандартын шаардлага хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Хичээлийн байр, сургалтын танхим, лаборатори, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа зэргээс суралцах нөхцөл хангагдсан гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Дотуур байрны тав тухыг сайжруулах, багаар болон бие даан ажиллах танхимын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Цайны газрын менежмент, хоолны амт чанарыг сайжруулах, хоолны сонголтыг нэмэгдүүлэх

- Биеийн тамирын заалны тохижилтыг сайжруулах, эрэгтэй оюутнуудыг хувцас солих өрөөгөөр хангах
- Багш нарын ажиллах нөхцөлийг сайжруулах (лекцийн анги танхимаар дамжсан, ерөөний зай бага)

Зөвлөмж:

- Оюутан, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар сургуулийн орчинг удаа дараа хамгийн муу гэж үнэлсэн тул түүнийг сайжруулах төлөвлөгөө гаргаж, үе хэрэгжүүлэх
- Хамтрагч байгууллагуудтай оюутны дадлагын үед баримтлах аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулж, мөрдүүлэх (төмөр замын тээвэр, авто тээвэр)
- Логистик хөтөлбөрийн оюутнуудад зориулсан лабораторийг нэмэгдүүлэх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Сургалтанд хэрэглэх программ хангамж, хэрэглэгдэхүүний судалгаа (лицензтэй программтай Vissim 800-13, Any logic), LMS Microsoft teams
- Сургалтанд ашиглах компьютер болон тоног төхөөрөмжийн судалгаа
- Цахим хичээлд бэлтгэх Light board студи
- Өөрсдийн боловсруулсан ном, сурах бичиг, тараах материал
- Программ ашиглах зааварчилгаатай
- UNIMIS – дэх цахим сургалтын дэд системээр дамжуулан түгээх хичээлийн багц материал
- Компьютерийн 3 лабораторитай

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж, E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал нь өнөөгийн нөхцөлд тохирч байна.

Анхаарах асуудал:

- Албан ёсны лицензтэй програмуудын хүрэлцээг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, улсын төсөвт үйлдвэрийн газар, Зүүнбаян төмөр зам ХХК, МТЗ ТӨХК, бусад хамтран ажилладаг

байгууллагуудын тусламжтайгаар лаборатори байгуулах, мөн тэдгээрийн ашиглаж буй лицензийг хамтран ашиглах арга зам хайх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, мэргэжлийн сэтгүүл (2015 оноос хойш Логистика сэтгүүл тогтмол захиалсан), цахим мэдээллийн сан,
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжуулалт хийгдсэн
- Цахим тестийн нээлттэй программууд ашигладаг (Padlet, Google form, Kahoot, Socrative г.м)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Багш нарын 50 хувь нь өөрийн боловсруулсан сурах бичигтэй
- Олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн эх үүсвэр ашиглах боломжтой
- Тээврийн чиглэлийн байгууллагуудтай хамтын ажиллагаатай, дадлагын баазтай
- Номын сангийн электрон каталогийн системтэй Lib4U

Анхаарах асуудал:

- Цахим сурах бичгийг нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Үндсэн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх
- Оюутны орчинд wi-fi хурдыг нэмэгдүүлэх
- Номын фонд бүрдүүлэхдээ ТЗДС-ийн номын сан, ИНЕГ-ын сургалтын төв болон бусад их сургуулиудтай хамтрах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн бичиг баримт
- Хөтөлбөрийн урт, богино хугацааны бодлого төлөвлөгөөний матриц
- “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2014 оны 03 сарын 13-ны өдрийн №А/78 тоот тушаал
- 2014 оны 04 сарын 28-ны өдрийн “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” №А/174 тоот тушаал
- ШУТИС-ийн ректорын 2014 оны 05-р сарын 06-ны өдрийн “Журам батлах, хөтөлбөрийн хороо байгуулах тухай” А/76 тоот тушаал
- UNIMIS-ийн системээр оюутан, багш, ажилтны оролцоог бүрэн хангадаг
- Хөтөлбөрт ирсэн санал, гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Давуу тал:**

- Хөтөлбөрийн баг нь МехТС-ийн хөтөлбөрийн дэд хороо болон, чанарын менежментийн зөвлөлөөр хэлэлцүүлсэний дараа ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо болон ХШҮГазраар батлуулж, эрдмийн зөвлөлөөр дахин хэлэлцэгдэж, албаждаг нь чанартай хөтөлбөр боловсруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудын санал хүсэлтийг тогтмол авч хэвших, тэдгээрийг хөтөлбөрийн сайжруултад тусгаж ажиллахад анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөр сайжруулах, шинэчлэх процессыг хурдасгах, шат дамжлагыг автоматжуулах, ШУТИС ба МехТС хоорондын ажлын уялдааг сайжруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Хамтын ажиллагаатай байгууллагуудтай гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, төсөл хөтөлбөр, гэрээт ажлын тайлан
- Багш, оюутаны солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан судалгаа
- Хөтөлбөрийн нийгэмд үзүүлсэн үйлчилгээ, ажлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Хөтөлбөрийн баг нь Зүүн өмнөд Азийн тээвэр судлалын нийгэмлэгийн гишүүн бөгөөд 2008 оноос хойш 2 жил тутам ЭШ-ний хуралд оролцдог уламжлалтай
- ОХУ-ын Байгалийн Улсын Их сургуультай хамтын ажиллагаатай

Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, төлөвлөгөөг албажуулах, урт хугацаанд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулахад анхаарах
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээллийн оновчтой сувгийг сонгох

Зөвлөмж:

- ✓ Хамтын ажиллагаатай байгууллагын тэтгэлгийн төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх
- ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлт, карьер хөгжил, чадавхижуулах сургалтын хэрэгцээ шаардлагын судалгааг тогтмолжуулж, үр дүнг хөтөлбөр шинэчлэхэд ашиглах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

- Нэг оюутанд ноогдох өртөг зардлын тооцоо
- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын судалгаа
- Логистик менежментийн хөтөлбөрийн оюутнуудад сургуулиас олгосон урамшуулал, тэтгэлгийн хэмжээний жагсаалт
- Тээврийн салбар хөтөлбөрийн үндсэн хөрөнгийн төсөв, орлого зарлагын тооцоо
- Багш нартай хийсэн уулзалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй гэдэг нь харагдаж байна.
- Зүүн өмнөд Азийн тээвэр судлалын нийгэмлэгийн зардлаар хөтөлбөрийн бүх багш нар 2 жил тутамд олон улсын уулзалт, семинарт оролцож, туршлага солилцдог.

Анхаарах асуудал:

- Эрдэм шинжилгээ, судалгаанаас олох орлогыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- ✓ Суралцагчдын тэтгэлгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цалинтай дадлага хийх боломжоор хангах
- Зүүн өмнөд Азийн тээвэр судлалын нийгэмлэгийн гишүүн шиг олон улсын байгууллагатай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

.....
4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт
Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Логистик менежмент хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Жил бүр ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулдаг

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, төрийн бодлогод нийцүүлэн элсэгчдийн тоог нэмэгдүүлэхийн тулд маркетингийн сувгийг оновчтой сонгож, сонирхогч талуудыг мэдээллээр (контент) тасралтгүй хангах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээ давуу тал, онцлогийг сурталчилсан олон төрлийн контентууд (подкаст, шторк, ярилцлага, сэтгэгдэл, нийтлэл, лайв г.м) боловсруулах
- Логистик менежмент чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад докторын зэрэг хамгаалсан багш, тэдний бүтээл, логистик менежментийн үндсэн сурах бичгээр дамжуулан хөтөлбөрийг зах зээлд таниулах

.....
4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал
Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

- ШУТИС болон МехТС-ийн үндсэн вэб сайт
- Facebook групп
- Дотоод дэд системүүд

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- UNIMIS систем, вэб сайтаар дамжуулан сургалтанд оролцогч талуудад мэдээлэл өгдөг
- Зөвлөх багш нараар дамжуулж суралцагчдад мэдээлэл өгдөг

Анхаарах асуудал:

- ✓ Гадаадын оюутан татахад чиглэсэн мэдээллийг ил тод, нээлттэй байлгах

Зөвлөмж:

- Логистик хөтөлбөрийн танилцуулгыг гадаад хэл дээр бэлтгэж, түгээх, вэб сайтад байршуулах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

- Суралцагчдад зориулсан ШУТИС-ийн дүрэм, журам
- Элсэлтийн журам, элссэн ба төгссөн оюутны тоон судалгаа
- Оюутны хөгжил, үйлчилгээний албаны хэрэгжүүлсэн ажлын тайлан
- Оюутны төлөөлөлтэй хийсэн уулзалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Зорилтот элсэгч элсүүлэхийн тулд мэргэжлийн багш нар, сургалтын алба, чанарын мэргэжилтэн нар хамтран ажилладаг

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- ✓ Мэргэжлийн хөтөлбөрийн сурталчилгааг ажил олгогч, амжилттай яваатөгсөгчийн туршлага жишээгээр баримтжуулсан сонирхолтой контент бүтээж, залуучуудын идэвхтэй сувагт байршуулах
- ✓ Эрэлт хэрэгцээтэй мэргэжил тул зорилтот элсэгчийн тоог нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- Элсэгчдэд зориулагдсан үйл ажиллагааны тайлан
- Элсэгчдийн дундаж онооны судалгаа
- Чиглүүлэх сургалт, зөвлөмж, уулзалт
- Ангийн зөвлөх багшийн уулзалт
- Оюутны холбооны ажлын төлөвлөгөө, тайлан
- Оюутны уулзалтын дүгнэлт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Сургалтын алба нь хичээл сонголт, сургалтын үйл ажиллагаа, шалгалтын дүн, сургалтын төлбөр төлөлтийн байдал зэрэг мэдээллүүдийг тогтмол хянаж, шаардлагатай бол үе шаттай хэлэлцүүлж, багш нартай хамтран ажиллаж үр дүнг нь оюутанд мэдээлдэг
- Тээвэр зуучлалын мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж, оюутнуудыг уралдаан тэмцээнд оролцуулдаг

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ буурч байгаа шалтгааныг тогтоож, нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- ✓ Төгсөгч, ажил олгогчид, суралцагч, мэргэжлийн багш нарын хамтарсан уулзалт, сургалтыг тогтмол явуулах
- ✓ Суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээг төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх арга зам эрэлхийлэх, тухайлбал Нийслэлийн авто замын түгжрэлийг арилгах чиглэлээр оюутнууд ажиглалт,

туршилт, судалгаа, шинжилгээ хийж үр дүнг нь холбогдох байгууллагад танилцуулан, шийдэл гаргахад хамтран ажиллах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

- Оюутантай хийсэн уулзалтын тэмдэглэл
- Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанли
- Оюутны зөвлөлийн ажлын тайлан
- Вэб сайт дах оюутан цэсэнд бүртгэгдсэн ажлууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- ШУТИС жил бүр оюутанд чиглэсэн ажилд тодорхой төсөв хийж, зарцуулж, оюутны холбоотой хамтарч ажилладаг.
- Оюутны хөдөлмөрийн биржтэй хамтарч ажилладаг.
- Цагийн болон байнгын ажлын байранд бүртгэх ажил цахимжсан.

Анхаарах асуудал:

- ✓ Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид зарим ажил тусгагдсан боловч нотлох баримт хангалтгүй байгаад анхаарах

Зөвлөмж:

- ✓ Оюутан нийгмийн сайн сайхны төлөө нийтийн боловсрол, байгаль орчин, эрүүл мэнд, зорилтот бүлгүүдэд чиглэсэн ажлуудыг хийж хувь нэмрээ оруулах, идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

- ШУТИС-ын захрилын А-147 тушаалаар шинэчлэгдсэн “Оюутны шилжилт, хөдөлгөөний журам”
- Оюутны шилжих хөдөлгөөний судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- Цөөн оюутантай тул оюутны шилжилт хөдөлгөөнийг хянахад хялбар

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний хувь хэмжээг ШУТИС-ийн бусад мэргэжлийн хөтөлбөрүүдийн дундаж хувь хэмжээтэй харьцуулж, судалгаа хийх
- Даасан ангийн оюутны мэдээллийг системээр харах боломжгүй

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оюутнуудыг тогтвортой суралцуулах, мэргэжилд дурлуулах ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх
- Системд ангийн багшийн модуль хөгжүүлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

- ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Европын кредит хөрвүүлэх системийг үндэслэсэн ШУТИС-ийн системтэй
- ШУТИС-ийн дипломын батлагдсан загвар

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/

Давуу тал:

- ШУТИС-ийн хэмжээнд төгсөлтийн баримт бичиг ерөнхий журамтай
- 3,6 ба түүнээс дээш үнэлгээтэй төгсөж байгаа тохиолдолд “Онцлох диплом” гэсэн тусгай тэмдэгтэй диплом олгодог

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Дипломыг блокчэйнээр баталгаажуулах ажлыг хийх
- Төгсөгчдөд цахимаар лавлагаа авах боломж олгох

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

- Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого нь дараах эрхзүйн баримт бичигт тулгуурладаг. Үүнд:
 - ШУТИС-ийн дүрэм
 - ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам
- Хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Хөтөлбөрийн 8 үндсэн багшийн 7 нь (87.5%) нь докторын зэрэгтэй. Үүнээс 5 нь Англи, Франц, ОХУ, БНСУ-д хамгаалсан.
- “Логистикийн менежмент” үндсэн сурах бичгийн зохиогчид энэ хөтөлбөрт ажиллаж байна.
- Хөтөлбөрийн багш нарын ажилласан жил, насны бүтцийн харьцаа сайн.
- Багш сонгон шалгаруулах, зэрэглэл тогтоох, урамшуулах үйл явц ил тод.

Анхаарах асуудал:

- Шилдэг багш нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг маш сайн бүрдүүлэх

Зөвлөмж:

- Бусад ИДС-ийн мэргэжлийн багш нартай харилцан туршлага солилцох хамтын ажиллагааг хөгжүүлэх (хамтарсан хичээл заах, хамтарсан сурах бичиг, гарын авлага бичих, эрдэм шинжилгээ судалгааны ажил, өгүүлэл бичих г.м)

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

- Багшийн хөгжлийн төв
- Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Хөтөлбөрийн 3 багш Чанарын менежментийн багт ажиллаж, сургагч багш хийдэг.
- Хөтөлбөрийн багш нар жил бүр CDIO болон ISO стандартын сургалтуудад хамрагддаг.
- Хөтөлбөрийн бүх багш нар Зүүн Өмнөд Азийн Тээвэр судлалын нийгэмлэгийн гишүүн ба бусад орны судлаачидтай сургалт, эрдэм шинжилгээний туршлага хуваалцаж өөрийгөө хөгжүүлэх боломжтой болсон.

Анхаарах асуудал:

- Багш нарын өөрийгөө хөгжүүлэх цаг, боломжийг нэмэгдүүлэх
- Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийг тодорхойлж, биелэлтэд нь үнэлгээ хийх, үр дүнгээр нь урамшуулах асуудлыг холбогдох журамд тусгах
- Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлж авч явах шинэ залуу багш нарыг дагалдуулан сургаж бэлтгэх

Зөвлөмж:

- Багш нарыг мэргэжлийн чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах боломжийг албажуулж, бодит кейс дээр ажиллуулж, практик ур чадварыг нэмэгдүүлэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол гүйцэтгэж, үр дүн гаргахад чиглэсэн бодлогын баримт бичиг, дүрэм, журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Хөтөлбөрийн 2 багш бусад гадаадын судлаачидтай хамтран Томсон-Ройтерсийн индекстэй ОУ-ын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлж, 15 бүтээлд эшлэгдсэн.
- Хөтөлбөрийн багш нар туурвисан бүтээлдээ зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан.
- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн 38%-ийг гадаадад хэвлүүлсэн болон хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл эзэлж байна.

Анхаарах асуудал:

- Улсын хэмжээний логистикийн тулгамдсан асуудал руу чиглэсэн судалгаа, төсөл хөтөлбөр, захиалгат судалгаанд оролцох багш нарын хувь хэмжээг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих төсвийг нэмэгдүүлэх
- Логистикийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх судалгааны ажлыг дотоодын санхүүжилтээр гүйцэтгэх, үр дүнг нь төр-хувийн хэвшлийн байгууллагад танилцуулах замаар хамтарсан судалгааны ажлыг нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцох талаар гарсан дүрэм, журам
- Дээрх дүрэм, журмын хүрээнд хийгдсэн үнэлгээний тайлан
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан,

Давуу тал:

- Багш сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил бүр өөрийн үнэлгээг цахимаар хийдэг.
- Суралцагчдаас багшийн заах аргазүй, ур чадварыг үнэлэх цахим системтэй.
- Багш нар нээлттэй хичээл хийж бусад багш нар хичээлд нь сууж үнэлгээ өгч, харилцан туршлага солилцдог.

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн үнэлгээний тайлангийн загварыг сургуулийн болон тухайн багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сайжруулах
- Профессор багшийн хийж гүйцэтгэсэн ажлыг үнэлэх системийг боловсронгуй болгох (жишээ нь дэд профессорын эрдэм шинжилгээ, судалгааны ажил 300, сургалт 500, сургууль, олон нийтийн үйлчилгээ 200 оноо)

Зөвлөмж:

- Багшийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хянах, үр дүнгээр нь урамшуулах системийг боловсронгуй болгох
- Багш нарын сэтгэл ханамжийн судалгаа хийх

.....
6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

- 2017 оны 05 сарын 17-ны А43 тоот тушаалын хавсралт: MeXTC-ийн Чанарын менежментийн загвар
- 2018 онд ISO 9001:2015 хэрэгжүүлсэн тайлан
- 2019 оны 4-р сарын 01-ний өдрийн А/2 тушаал (нийт 28 хүний бүрэлдэхүүнтэй, 5 дэд зөвлөлтэй Чанарын менежментийн зөвлөл)
 - Логистик менежмент хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
 - Суралцагч оюутнуудаас авсан санал асуулга
 - Төгсөгчдөөс авсан санал асуулга
 - Ажил олгогчдоос авсан санал асуулга

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Сургуулийн нэгдсэн чанарын албаас гадна бүрэлдэхүүн сургууль бүрд менежерээр ахлуулсан багтай (ШУТИС 2017)
- ЧБТ-ы дотоодын аудиттай ба жилд 1 удаа хийдэг.
- Дотоод хяналт, шалгалтын журамтай
- Чанарын менежменттэй холбоотой мэдээлэл, дүрэм журмыг вэб өгөх цэстэй
- Багш, ажилтны өөрийн үнэлгээний системийг хэрэгжүүлэх журам гм олон журамтай
- Өөрийн үнэлгээний тайлан
- Дотоод аудит, мониторинг, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт
- Суралцагч/ багш ажилтны санал, хүсэлт

- Хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ дараах чиглэлүүдээр хийлгэнэ.
Үүнд: - Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
- Хөндлөнгийн үзлэг, шалгалт буюу Чанарын аудит
- Хөтөлбөрийн төгсөгч болон ажил олгогчдын санал хүсэлт

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын дотоод болон хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг баримтжуулахад анхаарах
- Санал гомдол шийдвэрлэсэн байдлыг бүртгэлжүүлэх

Зөвлөмж:

- ISO9001 хэрэгжүүлсэн туршлагадаа үндэслэн Логистик менежментийн хөтөлбөрийн удирдлагын процессийг зураглах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Баримт нотолгоо:

- Төгсөгчдийн мөшгих судалгаа
- Оюутнуудаас авсан судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Ажил олгогчоос авсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, 4 жилээр хийгдсэн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ хийгдсэн
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийгддэг

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн карьер өсөлт, сэтгэл ханамжийн судалгаа тогтмол хийж хэвших, үр дүнг нь хөтөлбөрийн сайжруулалтад тусгах
- Ажил олгогчдын судалгааг тогтмол хийж, хөтөлбөрийг шинэчлэхэд ашиглах
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаанд багш, оюутан, ажил олгогч, төгсөгчийн оролцоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Оролцогч болон сонирхогч талуудын хамтын ажиллагааны үндсэн дээр хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахад чиглэсэн дэс дараалалтай үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх

.....

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Баримт нотолгоо:

- 2017 оны 02 сард 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан “Чанарын менежментийн зөвлөл”-ийн тушаал
- 2019 оны 4-р сарын 01-ний өдрийн 28 хүний бүрэлдэхүүнтэй, 5 дэд зөвлөлийн А/2 тушаал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Давуу тал:

- Байгууллагын МИ- 2018 онд 4 дэх удаагаа хийлгэсэн
- МехТС ISO 9001:2015 гэрчилгээ (2018.5)

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг нотлох судалгаа, дараагийн шатны болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан тухай шинжилгээ дутмаг байгааг анхаарах
- Мэргэжлээрээ ажиллах хувь хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Төгсөгчдийн дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх, тэднийг тасралтгүй чадавхжуулах сургалтад хамруулах, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- Дотоод болон олон улсын мэргэжлийн холбоод, их дээд сургуулиудтай хамтын ажиглагаагаа өргөжүүлж, хөтөлбөрийн нэр хүнд, имиджийг нэмэгдүүлэх

.....

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн МехТС-ийн “Логистик менежмент” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багийн тайлан, сургууль дээр ажилласан байдал, оюутан, төгсөгч, багш, ажил олгогч нартай хийсэн ярилцлага болон нэмэлт тодруулгаар авсан нотлох баримт, тайлан, судалгааны үр дүнг үндэслэн хөтөлбөрт магадлан итгэмжлэлийг 7 шалгуураар дараах байдлаар үнэллээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан / хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Нэгдсэн үнэлгээ		<u>БҮРЭН ХАНГАСАН</u>			

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ШУТИС, МехТСургууль
Хөтөлбөрийн нэр	“Логистик менежмент” хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс	D041305
Зөвлөмж	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн хөгжүүлэлт хийхдээ Монгол улстай ижил далайд гарцгүй орны их сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулах, олон улсын ИДС-ийн сургалтын төлөвлөгөөнд заавал орохоор тусгасан хичээлийн жагсаалтыг гаргаж ажиллах ✓ Мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчдийн уулзалтыг тогтмолжуулж, тэдний санал хүсэлтийг авч, сургалтын хөтөлбөртөө сайжруулалт хийж хэвших ✓ Хөтөлбөрийн холбогдолтой баримт бичиг, нотолгоог хадгалах, архивжуулах ажил хариуцсан ажилтан, алба нэгжийг тодорхой болгож, ажил үүргийн хуваарийг ажлын байрны тодорхойлолтод тусган ажиллах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ✓ Дадлагын удирдамжийг дадлага хийх байгууллагуудтай хамтран шинэчлэх замаар удирдагч багш, удирдагч ажилтан, оюутны үүрэг, хариуцлагыг тодорхой болгох ✓ Сургалтын орчин үеийн арга зүйг эзэмшсэн багшийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх (бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд) ✓ Оюутны дүнгийн шинжилгээнд үндэслэн суралцагчийн үнэлгээг тасралтгүй сайжруулах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> ✓ Оюутан, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар сургуулийн орчинг удаа дараа хангалтгүй гэж үнэлсэн тул түүнийг сайжруулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ✓ Хамтрагч байгууллагуудтай оюутны дадлагын үед баримтлах аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулж, мөрдүүлэх (төмөр замын тээвэр, авто тээвэр) ✓ Логистик хөтөлбөрийн оюутнуудад зориулсан лабораторийг нэмэгдүүлэх ✓ Үндсэн сурах бичгийн тоог нэмэгдүүлэх, номын фонд бүрдүүлэхдээ ТЗДС-ийн номын сан, ИНЕГ-ын сургалтын төв болонбусад их сургуулиудтай хамтрах ✓ Оюутны орчинд wi-fi хурдыг нэмэгдүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөр сайжруулах, шинэчлэх процессыг хурдасгах, шат дамжлагыг автоматжуулах, ШУТИС ба МехТС хоорондын ажлын уялдааг сайжруулах ✓ Хамтын ажиллагаатай байгууллагын тэтгэлгийн төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх

	<ul style="list-style-type: none"> ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлт, карьер хөгжил, чадавхижуулах сургалтын хэрэгцээ шаардлагын судалгааг тогтмолжуулж, үр дүнг хөтөлбөр шинэчлэхэд ашиглах ✓ Хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээ давуу тал, онцлогийг сурталчилсан олон төрлийн контентууд (подкаст, шторк, ярилцлага, сэтгэгдэл, нийтлэл, лайв г.м) боловсруулах ✓ Логистик менежмент чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудад докторын зэрэг хамгаалсан багш, тэдний бүтээл, логистик менежментийн үндсэн сурах бичгээр дамжуулан хөтөлбөрийг зах зээлд таниулах ✓ Логистик хөтөлбөрийн танилцуулгыг гадаад хэл дээр бэлтгэж, түгээх, вэб сайтад байршуулах
<p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Оюутан нийгмийн сайн сайхны төлөө нийтийн боловсрол, байгаль орчин, эрүүл мэнд, зорилтот бүлгүүдэд чиглэсэн ажлуудыг хийж хувь нэмрээ оруулах, идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх ✓ Хөтөлбөрийн оюутнуудыг тогтвортой суралцуулах, мэргэжилд дурлуулах ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх ✓ Дипломыг блокчэйнээр баталгаажуулах ажлыг хийх ✓ Төгсөгчдөд цахимаар лавлагаа авах боломж олгох
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Бусад ИДС-ийн мэргэжлийн багш нартай харилцан туршлага солилцох хамтын ажиллагааг хөгжүүлэх (хамтарсан хичээл заах, хамтарсан сурах бичиг, гарын авлага бичих, эрдэм шинжилгээ судалгааны ажил, өгүүлэл бичих г.м) ✓ Багш нарыг мэргэжлийн чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах боломжийг албажуулж, бодит кейс дээр ажиллуулж, практик ур чадварыг нэмэгдүүлэх ✓ Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих төсвийг нэмэгдүүлэх ✓ Багшийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг хянах, үр дүнгээр нь урамшуулах системийг боловсронгуй болгох ✓ Багш нарын сэтгэл ханамжийн судалгаа хийх
<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> ✓ ISO9001 хэрэгжүүлсэн туршлагадаа үндэслэн Логистик менежментийн хөтөлбөрийн удирдлагын процессийг зураглах ✓ Төгсөгчдийн дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх, тэднийг тасралтгүй чадавхжуулах сургалтад хамруулах, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ✓ Дотоод болон олон улсын мэргэжлийн холбоод, их дээд сургуулиудтай хамтын ажиглагаагаа өргөжүүлж, хөтөлбөрийн нэр хүнд, имиджийг нэмэгдүүлэх

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Анхтуяа
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Бат-Оргил
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Н.Отгонсайхан

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Ажилласан жил
1	С. Ариунбаяр	Хөтөлбөр хариуцсан дэд профессор	Логистик Логистикийн мэдээллийн систем Логистик инженерчлэл Худалдааны логистик	16
2	Д.Өнөрсайхан	Чанарын менежер	Агуулахын аж ахуй Нөөцийн удирдлага Нийлүүлэлтийн хэлхээний менежмент	9
3	Б.Батбаяр	Ахлах багш	Үйлдвэрлэлийн логистик Төмөр замын тээврийн менежмент	15
4	Ж.Азжаргал	Ахлах багш	Төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүн Төмөр замын дэд бүтэц, инженерчлэл	23
5	Л.Чулуунцэцэг	Ахлах багш	Логистикийн үндэс Логистик зардлын удирдлага Тээврийн нэгдсэн систем	22
6	С.Уянга	Ахлах багш	Олон улсын стандарт эрхзүй Олон улсын тээвэр зуучлалын менежмент	6
7	Г.Ариунбямбаа	Багш	Харилцааны англи хэл Бизнес менежментийн англи хэл Тусгай зориулалтын англи хэл	18
8	Д.Содномзул	Ахлах багш	Микро эдийн засаг Макро эдийн засаг	14

II. Оюутны нэрс

№	Оюутны овог, нэр	Анги	Сонгосон байдал
1	Баянмөнх	Логистик менежмент 2	Хотоос
2	Мөнхтүшиг	Логистик менежмент 2	Хотоос
3	Б.Золзаяа	Логистик менежмент 3	Шилжиж ирсэн
4	Т.Энхсугар	Логистик менежмент 3	Ажил хийдэг
5	Ч.Үнэнтөгс	Логистик менежмент 3	хотоос
6	Г.Чанцалдулам	Логистик менежмент 4	Хотоос
7	Б.Өлзий-Орших	Логистик менежмент 4	Орон нутгаас
8	Б.Хулан	Логистик менежмент 4	Хотоос
9	Ц.Сүхбат	Логистик менежмент 4	Орон нутгаас
10	Ө.Анунгоо	Логистик менежмент 4	Хотоос
11	А.Одсүрэн	Логистик менежмент 4	Хотоос
12	Г.Хосцэцэг	Логистик менежмент 4	Хотоос
13	Р.Зөөлөн-Эгшиглэнт	Логистик менежмент 4	Дотуур байранд байсан
14	Г.Отгонтуул	Логистик менежмент 4	Орон нутгаас
15	Б.Ууганцэцэг	Логистик менежмент 4	Хотоос
16	Баттүшиг	Логистик менежмент 5	Хотоос
17	Хүслэн	Логистик менежмент 5	Хотоос
18	Б.Тунгалагмөрөн	Төмөр замын тээврийн менежмент	Таван Толгойд ажилладаг
19	Э.Тулга	Төмөр замын тээврийн менежмент	Таван Толгойд ажилладаг
20	Ц.Сүлд-Эрдэнэ	Төмөр замын тээврийн менежмент	Таван Толгойд ажилладаг
21	Г.Багтогтох	Төмөр замын тээврийн менежмент	Таван Толгойд ажилладаг
22	Л.Оюундэлгэр	Төмөр замын тээврийн менежмент	Таван Толгойд ажилладаг

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Ё.Жаргалсайхан	ЗТХЯам	АТБХЗГДарга
2	Сонинбаатар	Зорчигч тээвэр 3 ХК	Хэлтсийн дарга
3	Уранцэцэг	Landbridge ХХК	Хүний нөөцийн менежер
4	Давааням	Monex ХХК	Дэд захирал
5	Х.Булгаа	Нийтийн тээврийн газар	Орлогч дарга
6	Минжигмаа	Туушин ХК	ТЗХНДарга
7	Оюунчимэг	УБТЗ ХНН	Хүний нөөцийн газрын дарга
8	Г.Пүрэвдулам	ИНЕГ	Хүний нөөцийн газрын дарга
9	Гантуул	Эрдэнэс ТТТөмөр зам	ХНөөцийн мэргэжилгэн
10	Бат-Очир	Ачир ХХК	Тээврийн менежер
11	Буд-Эрдэнэ	Jurmak ХХК	Ерөнхий менежер
12	Б.Азжаргал	Mon Logistics holding ХХК	Хүний нөөцийн ахлах менежер
13	Амгалантөр	Тэнүүн Огоо ХХК	Ерөнхий инженер
14	Бат-Оргил	Прайд транс ХХК	Тээврийн зохицуулагч
15	Оюундарь	United Shipping LLC	Тээврийн менежер

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн овог нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1	Б.Долгорсүрэн	2017	Ландбридж ХХК, логистикийн мэргэжилтэн
2	П.Ануужин	2017	Ландбридж ХХК, логистикийн мэргэжилтэн
3	Б.Хулан	2017	Ландбридж ХХК, логистикийн мэргэжилтэн
4	Б.Уранбилэг	2017	Ландбридж ХХК, гаалийн мэргэжилтэн
5	П.Намуун	2017	Вэлл Бий ХХК, импортын мэргэжилтэн
6	Г.Мөнхжаргал	2017	Энсада Трактрон ХХК, мэргэжилтэн
7	Э.Марал	2017	МСМ групп ХХК, логистик администратор
8	Б.Маралмаа	2020	Алтай ложистик ХХК, тээврийн менежер
9	А.Хулан	2020	Нью Ложистик ХХК, логистик менежер
10	Ц.Барсболд	2020	Дөлгөөн аравт ХХК, мэргэжилтэн
11	Х.Өнөболд	2020	Ландбридж ХХК, харилцагчийн үйлчилгээний ажилтан
12	Н.Лхагва-Очир	2020	Дашваанжил ХХК, бүс хариуцсан мөнөжер
13	Э.Энх-амгалан	2020	Талын монгол HD телевиз ХХК, зураглаач
14	З.Отгонжаргал	2020	Омнишипинг ХХК, худалдааны менежер
15	Б.Буянхишиг	2020	Монложистик ХХК, тээврийн мэргэжилтэн
16	Э.Оюунбилэг	2020	Автотээврийн үндэсний төв, лавлах үйлчилгээний ажилтан

17	Г.Булган	2021	Гэр бүлийн бизнесдээ тусалж байгаа
18	Н.Болормаа	2021	Глобал ворлдвайд ХХК тээврийн мэргэжилтэн
19	Н.Энхтунгалаг	2021	Роял Ложистикс ХХК, тээврийн мэргэжилтэн

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ

17033 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Энгельсийн гудамж,
Утас/Факс: (976-11) 34 19 13,
И-мэйл: dtsolmon@must.edu.mn, Вэбсайт: must.edu.mn

2022.01.21 № 1134

танай _____ -ны № _____ -Т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНД

Хариу хүргүүлэх тухай

Тус сургуулийн Логистик менежмент /041305/ бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүсэлт болон Өөрийн үнэлгээний тайланг БМИҮЗ-д хүргүүлсний дагуу 2021 оны 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд БМИҮЗ-ийн шинжээчийн баг манай сургууль дээр ирж ажиллан шинжээчийн тайлангаа 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр бидэнд ирүүлээд байна.

Шинжээчийн тайланд Логистик менежмент /041305/ бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн шалгуур бүрт хамаарах анхаарах асуудал, зөвлөмжийг тусгажээ. Тус сургуулийн Өөрийн үнэлгээний багийн зүгээс шинжээчийн тайланг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд бид БМИҮЗ-ийн шинжээчийн багийн тайланд тусгагдсан анхаарах асуудал болон зөвлөмжийг сургалтын хөтөлбөрөө сайжруулах үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ



Д.ЦОЛМОНБААТАР

ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮШ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын
хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/